

БАРУУН-УРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

10 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2021.10.23

НЭГ.ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

10 дугаар сард тус Тамгын газраас явсан болон Тамгын газарт ирсэн бичиг

Явсан бичиг 35

Засаг дарга-12

Тамгын дарга-13

Ирсэн бичиг 40

- Хариутай бичиг 18
- Хугацаандаа явсан 7
- Хугацаа хоцорсон- 7
- Хугацаа болоогүй 4

Тус Тамгын газраас явсан бичгийг стандартын дагуу зохион бүрдүүлж ажилласан. Мөн ирсэн албан бичгийг удирдлагад цаг тухай бүрт танилцуулан холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгч ажиллалаа.

Тайлант сарын байдлаар удирдлагын гаргасан захирамж, тушаал

Засаг дарга

“А” захирамж-19

“Б” захирамж-4

Тамгын дарга

“Б” тушаал-8 тус тус гарсан байна.

Архивын лавлагааг 34 иргэн болон албан байгууллагад гарган өгсөн байна.

ХОЁР: БАЙГАЛЬ, ОРЧИН, ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

- Бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд 4,5-р тойргийн модыг усалж арчлах, шинээр мод тарих ажилд 45 ААНБ-н 1500 албан хаагч оролцож шинээр 2700 ш мод, 8-н багийн 160 өрх 800 ш мод тарьсан.
- Таван эрдэнэ малтай хорооллын хогийн цэгийг цэгцлэх ажлыг Цайрт Минериал ХХК-тай хамтран хийж гүйцэтгэсэн.
- Нохой устгалын ажлыг Багийн засаг дарга нарын хяналтан дор Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-тай хамтран 60 нохойг устгаж эрүүл аюулгүй орчинг бүрдүүлж ажилласан.
- Намрын их цэвэрлэгээг нийтийн эзэмшлийн талбайг хуваарийн дагуу 65 ААНБ 10-р сарын 09-ны өдөр зохион байгуулж нийт 120 м3 хогийг цэвэрлэсэн.
- Тогтвортой амьжиргаа -3 төсөл, БОАЖЯ-наас орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төслийн ажилд БОНБҮнэлгээ хийгдэх сургалт зохион байгуулагдсан.

- Сангийн яам, Худалдан авах ажиллагаатай холбоотой шинэчлэсэн журам, тендерийн жишиг баримт, цахим системийн танилцуулга сургалтанд 3 албан хаагч хамрагдсан.
- Ковид 19 халдварт өвчний явцын үнэлгээг аймгийн Тохиолдлын удирдлагын тогтолцооны багт оролцож хийсэн
- Засаг даргын орлогч Э.Хүрэлчулуунаар ахлуулсан ажлын хэсэгт 8-р багийн малчин өрхүүдээр явж намрын хуурайшилтын үед хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх санамж зөвлөгөөг 150 иргэнд хүргэсэн, мөн бэлчээрийн маргааныг шийдвэрлэж ажилласан.
- Малын халдварт өвчин үхрийн арьс товруутах өвчнөөр өвчилсөн 6 үхрийг устгах устгалын ажлын хэсэгт ажиллаж 2 устгалын цэгийг тодорхойлсон.
- Аймгийн төвөөс мал гаргах тухай Аймгийн засаг даргын 2019 оны А/247 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдрүү чиглэсэн мэдээ мэдээлэл бэлтгэж BBS телевизээр мэдээлэл өгөх, мал бүхий 10 иргэнтэй уулзсан. Мөн Сүхбаатар тохижилт үйлчилгээний газарт төвөөр явж буй малыг хашиж эзэд нь сануулах арга хэмжээ авч ажиллаж байна.
- Аймгийн ЗДТГ-н ХОХБХ, БОАЖГ-тай хамтран ирэх 2022 онд шинээр байгуулах ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлийн төслийг боловсруулан ажиллаж байна.
- Худалдан авах ажиллагааны аймгийн ЗДТГ-с шилжүүлсэн тендерийн дагуу Баруун-Урт сумын “4-р багийн хашааг шинэчлэх” тендер шалгаруулалт хийгдсэн.
- 48 айлын орон сууцны гадна пасадын ажил хийгдэж дууссан.
- Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын дээвэр засварын ажил хийгдэж дууссан.

ГУРАВ: ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

- Намрын ногоон өдрүүд үзэсгэлэнд Баруун-Урт сумын 30 гаруй өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг иргэн, аж ахуй нэгж, хоршоо оролцох ажлыг зохион байгуулж ажилласан
- Ээмэгжүүлэлтийн ажил хийгдэж байна.
- Малын хөлийн татварын талаар малчдад мэдээлэл хүргэх ажлыг 9 багийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.

ДӨРӨВ. ИРГЭДЭД ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ТҮРГЭН ШУУРХАЙ ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Тайлант хугацаанд иргэдэд шаардлагатай Багийн Засаг даргын 454 тодорхойлолт гаргаж үйлчилсэн байна.

Төрийн үйлчилгээний оператораас 13-н төрлийн 63 лавлагааг гарган иргэдэд түргэн шуурхай үйлчилсэн байна. Үүнийг ангиллавал:

1. Нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн талаар-18
2. Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа-12
3. Иргэний үнэмлэхний лавлагаа-11
4. Оршин суугаа хаяг -6

5. Шүүхийн шийдвэр бусдад өр төлбөргүй эсэх лавлагаа-4
6. Гэрлэлт бүртгэлгүй лавлагаа-2
7. Гэрэлсний бүртгэлийн лавлагаа-2
8. Жолоочийн үнэмлэх захилга -2
9. Гэрлэлт дуусгвар болсны лавлагаа-1
10. Иргэнд олгох тодорхойлт-1
11. Иргэний эрүүгийн хариуцлага-1
12. Үл хөдлөх хөрөнгөтэй эсэх лавлагаа-2
13. Үл хөдлөх хөрөнгийн жагсаалтын лавлагаа-1

Төлбөртэй үйлчилгээ-5

Тус сард Багийн ажлын алба Цэргийн зарлан дуудах хуудас тараах болон нохой устгал хийх, модны суулгац тараах ажлаар айл өрхөөр давхардсан тоогоор 3000 гаруй орж ажилласан. 9-р баг “Оюунлаг хайлааст” номтой цүнх бэлэглэх ажлын хүрээнд багийн 75 айлаар орж мэдээ мэдээлэл хүргэн ажилласан.

Багийн ажлын албанаас санаачлан ГБХЗХГ, Хайртай бренд, 9 дүгээр багийн иргэдийн нийтийн хурлын дарга А.Нарантуяа нар хамтарн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг 5 ээжийг хамруулан 2 өдрийг оёдлын сургалтыг зохион байгуулж ээж нар өөрсдөө дээлээ эсгэн оёж бэлэн болгосон.

Сүхбаатар аймгийн “Сүхбаатар” өнгө сонинд e-mongolia төрийн үйлчилгээний операторийн үйл ажиллагааг танилцуулахаар хэвлэл мэдээлэл оруулж нийтэлсэн.

“Намрын ногоон өдрүүд” нээлттэй хаалагны өдөрлөгт оролцон e-mongolia төрийн үйлчилгээ иргэдэд сурталчлан таниулан ажилласан.

9-н багийн групп хаяганд цаг тухай үеийн шинэ мэдээ мэдээллийг цахим орчимд баршуулж мэдээлэл түээсэн.

Иргэдэд өдөр тутам үйл ажиллагаагаа сурталчлан гарын авлага тарааж мэдээлэлээ түгээж байна. Мөн утасаар e- Mongolia аппликэйшн үйлчилгээ авах боломжийг танилцуулан үйл ажиллагаагаа тогтмолжуулсан.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 63 тоот зарлиг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр, Нэг тэрбум мод тарих хөдөлгөөны хүрээнд Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх иргэдийн мод тарих хүсэл, сонирхлыг нэмэгдүүлэх, урамшуулах, зорилгоор орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар 9 багийн иргэдэд 750 ш шар хуайс, үхрийн нүд, голт бор, бөөрөлзгөнө, нохойн хошуу суулгацыг өгч, тарилтын ажлыг зохион байгуулсан.

2021 оны 2-р ээлжээр хугацаат цэргийн албанаас чөлөөлөгдөж буй цэргийн албан хаагчдыг цар тахлын дүрэм журмыг баримтлан албан ёсоор угтан авч хүндэтгэл үзүүлэн, ар гэрт нь хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан. 2-р ээлжийн цэрэг татлага 10-сарын 15-16 өдрүүдэд амжилттай зохион байгуулж, хяналтын тоонд хүргэж ажилласан.

Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар